



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас/Факс: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2022.12.30 № 1/1547
танай 2022.12.14 -ны № 3/5586 -т


**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗАРТ**

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон тус газрын 2022 оны 12 сарын 14-ний өдрийн 3/5586 “Тайлан ирүүлэх тухай” албан бичгийн дагуу 2022 онд УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасагт “ORBIS INTERNATIONAL” олон улсын байгууллагын санхүүжилт, дэмжлэгтэй хэрэгжсэн “Монгол Улсад нүд судлалын салбарт сургалтын шинэлэг загварыг бий болгох нь” төслийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

**ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХИШИГЖАРГАЛ**



002825

“МОНГОЛ УЛСАД НҮД СУДЛАЛЫН САЛБАРТ СУРГАЛТЫН ШИНЭЛЭГ ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОХ НЬ” ТӨСЛИЙН ТАЙЛАН

2022 онд УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасагт “ORBIS INTERNATIONAL” олон улсын байгууллагын 12.000\$ санхүүжилт, дэмжлэгтэй хэрэгжсэн “Монгол Улсад нүд судлалын салбарт сургалтын шинэлэг загварыг бий болгох нь” төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээ. Үүнд:


НЭГ: АЖЛЫН БАЙРНЫ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

1. УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасаг болон Олон улсын Орбис эрүүл мэндийн байгууллагын хамтарсан эмч нарын баг бүрэлдэхүүн 2022 оны 05 сарын 18-аас 22-ны өдрүүдэд Ховд, Хөвсгөл аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвд “Алслагдсан бүс нутагт нүдний тусламж үйлчилгээг чанартай хүргэх загвар” төслийн хүрээнд жижиг зүслэгт болрын мэс заслыг аймгийн нүдний эмч, сувилагч нартай хамтран 25 иргэнд хийж, 50 гаруй иргэдийг үзлэг оношилгоонд хамруулж, “Болрын мэс заслын үеийн зарим хүндрэлүүд” сэдвээр ажлын байрны сургалт зохион байгуулсан.



Ажлын байрны сургалт болон хамтарсан мэс заслыг хийж байгаа нь

2. УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасгийн зөвлөх эмч Б. Төмөрбаатар ахлагчтай 9 эмчийн баг бүрэлдэхүүн 2022 оны 07 дугаар 19-ны өдрөөс 23-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн 12 суманд нүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг 1128 иргэнд хийж 53%-д нүдний эмгэг илрүүлсэн.
3. УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасгийн эмчийн баг бүрэлдэхүүн 2022 оны 10 сарын 1-ээс 7-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажиллаж хамтарсан нүдний мэс заслыг хийж ажлын байрны сургалт зохион байгуулсан. Мөн Нүд судлал, мэс заслын тасгаас эрхлэн гаргасан “Нүдний анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх” гарын авлагыг нийт суралцагч нарт тараасан.



Сэлэнгэ аймагт ажилласан эмчийн баг бүрэлдэхүүн

ХОЁР: ТАНХИМИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасаг болон Олон улсын Орбис эрүүл мэндийн байгууллага, Монголын нүдний эмч нарын нийгэмлэг, Залуу нүдний эмч нарын клуб хамтран 2022 оны 02 дугаар 26-ны өдрөөс 03 дугаар сарын 13-ны хооронд “Алслагдсан бүс нутагт нүдний тусламж үйлчилгээг чанартай хүргэх загвар” төслийн хүрээнд дараах сэдвүүдээр 12 цагийн лекц, 24 цагийн вет лабораторийн дадлага бүхий сургалтыг зохион байгуулж 18 нүдний эмч хамрагдсан.

1. MSICS мэс заслын алхамуудын ерөнхий ойлголт ба салстын зүслэг, склерийн туннель гаргах дэлгэрэнгүй арга, аргачлал
2. Парацентез хийх, вискоэластик (төрлүүд болон зориулалт), өмнөд хоргын зохицуулагчийг ашиглах дэлгэрэнгүй арга, аргачлал
3. Өмнөд капсулорексис (лааз онгойлгогч, үргэлжилсэн тойрог, “V”), гидродиссекци, болрын цөмийг гаргах дэлгэрэнгүй арга, аргачлал
4. Биометрийн шинжилгээг гардан хийх, IOL сонголт
5. Мэс заслын микроскопийг хэрхэн ашиглах тухай, MSICS мэс заслын үндсэн багажуудыг таньж, зориулалт, хэрхэн ашиглах тухай
6. Мэс заслын мэдээ алдуулалт, мэс заслын бэлтгэл
7. Оёдол, зангилаа тавих аргачлал, эвэрлэгийн урагдлыг засах
8. Кортексийг гаргах, IOL суулгах, ирригаци/аспираци, шарх хаах дэлгэрэнгүй арга аргачлал
9. Өвчний зөвшөөрлийн хуудас ба Үндсэн бичиг баримтууд
10. Хүндрэлтэй катарактын менежмент, мэс заслын дараах эмийн эмчилгээ
11. Түгээмэл тохиолдох мэс заслын хүндрэлүүдийн үед авах арга хэмжээ



Сургалтанд хамрагдсан нийт эмч нар




Нүдний мэс заслын хиймэл орчин бүрдүүлсэн лабораторт дадлага хийж буй эмч нар

ГУРАВ: ЦАХИМ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасаг болон Олон улсын Орбис эрүүл мэндийн байгууллага хамтран хэрэгжүүлсэн “Алслагдсан бүс нутагт нүдний тусламж үйлчилгээг чанартай хүргэх загвар” төслийн хүрээнд доорхи цахим сургалтуудыг 2022 оны 4 болон 8 дугаар сард 2 удаа нийт нүдний мэс заслын эмч нарт зориулан зохион байгуулсан.

Сургалтын сэдэв, огноо, чиглүүлэгч багш

№	Сэдэв	Огноо	Багш
1	SICE/Small incision cataract extraction by Zoom /	2022/04/02 10:00 – 12:00	С.Энхтуул
2	SICE/Small incision cataract extraction by Zoom /	2022/08/01 10:00 – 12:00	П.Бүрэнжаргал



Цахим сургалт хийгдэж буй үйл явц

ДӨРӨВ: ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХАНГАН НИЙЛҮҮЛСЭН ЧИГЛЭЛЭЭР

УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасаг болон Олон улсын Орбис эрүүл мэндийн байгууллага хамтран хэрэгжүүлсэн “Алслагдсан бүс нутагт нүдний тусламж үйлчилгээг чанартай хүргэх загвар” төслийн хүрээнд Нүд судлал мэс заслын тасагт 6 нэр төрлийн 18 ширхэг, **5.7** сая төгрөгийн өртөг бүхий болрын мэс засалд нэн шаардлагатай багажнуудыг ханган нийлүүлсэн. Мөн жижиг зүслэгт болрын мэс заслын цахим сургалт хийх шаардлагатай компьютер, дагалдах хэрэгслүүдийг төслийн санхүүжилтээр ханган нийлүүлж холбогдох журмын дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгүүлсэн.